



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.03.06 № 71/1254

танай 2025.02.20-ны № 08 -т

**БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГА Н.ЭРХЭМБАЯР ТАНАА**

“Албан татварын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
Булган аймгийн Бүрэгхангай сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 14-ний
өдрийн III/03 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий
хуулийн дагуу хянаад захиргааны хэм хэмжээний актын
улсын нэгдсэн сангийн ...4157..... дугаарт бүртгэснийг
үүгээр хүргүүлэв.



О.АЛТАНГЭРЭЛ



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 03 сарын 06-ны
өдрийн 1157 дугаарт бүртгэн.

БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГ ХАНГАЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 17/03

Дархан баг

Г

Г

Албан татварын хэмжээг
шинэчлэн тогтоох тухай


Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.6 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн ээлжит бус III хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. 2023-2024 онуудад байгаль цаг агаарын хүндрэлтэй нөхцөл үүсэж цагаан зудтай байснаас мал сүрэг ихээр хорогдож малчдын амьжиргаа буурсан тул 2025 оны малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг 2025 онд малыг төрөл тус бүрээр 0 (тэг) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2. Уг тогтоолыг баталсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай" 03/04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (Э.Эрдэнэбулган)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЭРХЭМБАЯР

